**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

**Булган сумын ЕБС-ийн Минжит булган цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код: ХОА-2022/108/НА-СТА-ТШ3**

---

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот

2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Эл Би Альфа аудит ХХК-ны

Аудитор: Б.Бадамцэцэг

Утас: 70432545

цахим хаяг:

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................................ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ...................................................................... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .................................................................. 6
2.3 Аудитхийсэнцэвэрхөрөнгө/өмчийнөөрчлөлтийнтайлан .................................................. 8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.......................................................................... 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан..................................................................... 9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..................................................... 11
3.Аудитын тайлан.................................................................................................................. 14
3.1 Ерөнхий зүйл........................................................................................................................ 14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ................................................................... 14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........................................................................ 15
3.4Материаллаг байдал............................................................................................................. 15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..................................................................................... 15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв ..................................................................... 16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .......................................................... 17
3.8 Аудитын гол асуудал ........................................................................................................... 17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..................... 17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ....................................................................... 17
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ................................................................................................ 17
3.11Дараагийн аудитаар анхаарах асуудал ............................................................................ 17
4. Аудитын илрүүлэлт ............................................................................................................ 17
4.1 Албан шаардлага.............................................................................................................. 18
4.2 Зөвлөмж ............................................................................................................................ 18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл........................ **Error! Bookmark not defined.**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| НА | Нотлох ажил |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |

Төсвийн захирагч

...................... ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу .......... -ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

.......... -ын 20... оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

Албан тушаал, Гарын үсэг, Тамга

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **93,763,344.68** | **112,144,565.28** |
| **33** | **АВЛАГА** | 2,940,707.40 | 00.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,940,707.40 | 00.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 00.00 | 13,000,000.00 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 00.00 | 13,000,000.00 |
| 34712 | Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 00.00 | 13,000,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 90,822,637.28 | 99,144,565.28 |
| **351** | **Түүхий эд материал** | 10,285,984.00 | 8,039,184.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 6,174,534.00 | 6,174,534.00 |
| 35130 | Эм боох материал | 4,111,450.00 | 1,864,650.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 80,536,653.28 | 91,105,381.28 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 22,245,216.00 | 24,372,396.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,766,000.00 | 10,121,400.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 33,358,523.78 | 38,871,661.78 |
| 35450 | Барилгын засварын материал | 750,750.00 | 750,750.00 |
| 35460 | Хүнсний материал | 16,416,163.50 | 16,989,173.50 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,984,183,464.27** | **1,890,175,840.75** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,984,183,464.27 | 1,890,175,840.75 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,879,516,064.27 | 1,785,508,440.75 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,828,167,461.00 | 1,854,167,461.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -253,811,007.80 | -371,030,574.52 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 26,000,000.00 | 26,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -21,666,666.29 | -26,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 322,908,809.58 | 344,963,809.58 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -249,782,925.00 | -271,740,229.80 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 322,459,805.00 | 333,640,417.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -138,889,683.04 | -153,092,668.65 |
| 39217 | Ном | 44,130,270.82 | 48,600,226.14 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 104,667,400.00 | 104,667,400.00 |
| 39301 | Програм хангамж | 330,000.00 | 330,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 104,612,400.00 | 104,612,400.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -275,000.00 | -275,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,077,946,808.95** | **2,002,320,406.03** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **00.00** | **11,454,345.78** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 00.00 | 11,454,345.78 |
| **413** | **Өглөг** | 00.00 | 11,454,345.78 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 00.00 | 2,359,841.20 |
| **4136** | **Бусад өглөг** | 00.00 | 9,094,504.58 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 00.00 | 9,094,504.58 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,077,946,808.95** | **1,990,866,060.25** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,077,946,808.95 | 1,990,866,060.25 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,937,494,876.00 | 1,937,494,876.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,937,494,876.00 | 1,937,494,876.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -1,065,883,041.74 | -1,152,963,790.44 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -1,065,883,041.74 | -1,066,222,134.53 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -86,741,655.91 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,206,334,974.69 | 1,206,334,974.69 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,077,946,808.95** | **2,002,320,406.03** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,802,909,928.58** | **1,801,351,867.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **82,598,700.58** | **67,489,887.32** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 82,598,700.58 | 67,489,887.32 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 82,598,700.58 | 67,489,887.32 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,350,000.00 | 600,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 81,248,700.58 | 66,889,887.32 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **99,171,028.00** | **131,224,280.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,621,140,200.00 | 1,602,637,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 36,533,444.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 36,533,444.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 93,230,200.00 | 94,505,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 93,230,200.00 | 94,505,900.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 5,940,828.00 | 184,936.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 5,940,828.00 | 184,936.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,845,662,475.62** | **1,888,093,523.23** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,845,662,475.62** | **1,888,093,523.23** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,706,100,318.49 | 1,788,683,140.97 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,272,648,348.55 | 1,299,602,034.69 |
| 210101 | Үндсэн цалин | 1,246,726,986.55 | 1,299,602,034.69 |
| 210104 | Урамшуулал | 25,921,362.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 163,707,168.32 | 173,099,141.44 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 163,707,168.32 | 173,099,141.44 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 72,292,995.00 | 88,668,462.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,097,990.00 | 18,311,990.88 |
| 210302 | Түлш, халаалт | 58,195,005.00 | 69,744,471.12 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 612,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 21,834,401.22 | 21,639,972.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,657,460.00 | 11,290,704.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,749,000.00 | 00.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,891,084.00 | 1,295,339.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 802,400.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 653,499.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,734,457.22 | 8,400,430.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 30,828,780.00 | 43,009,590.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,478,050.00 | 6,509,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 27,350,730.00 | 36,499,790.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 585,100.00 | 489,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 585,100.00 | 489,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,400,000.00 | 2,958,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 1,950,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,400,000.00 | 1,008,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 142,803,525.40 | 159,216,440.84 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 310,000.00 | 661,750.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,467,000.00 | 841,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 141,026,525.40 | 157,713,190.84 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 139,562,157.13 | 99,410,382.26 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 33,676,128.00 | 59,987,080.98 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 5,940,828.00 | 184,936.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 27,735,300.00 | 37,362,132.98 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 22,440,012.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 105,886,029.13 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 105,886,029.13 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 39,423,301.28 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 39,423,301.28 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-42,752,547.04** | **-86,741,655.91** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 64,565,220.58 | 00.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 20,208,208.00 | 00.00 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 44,357,012.58 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -64,565,220.58 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-107,317,767.62** | **-86,741,655.91** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,937,494,876.00 | 1,206,334,974.69 | -1,002,922,286,70 | 2,140,907,563.99 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,937,494,876.00** | **1,206,334,974.69** | **-1,002,922,286,7** | **2,140,907,563.99** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -62,960,755.04 | -62,960,755.04 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,937,494,876.00** | **1,206,334,974.69** | **-1,065,883,041.74** | 2,077,946,808.95 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,937,494,876.00** | **1,206,334,974.69** | **-1,065,883,041.74** | 2,077,946,808.95 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | -339,092.79 | -339,092.79 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,937,494,876.00** | **1,206,334,974.69** | **-1,066,222,134.53** | 2,077,607,716.16 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -86,741,655.91 | -86,741,655.91 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,937,494,876.00** | **1,206,334,974.69** | **-1,152,963,790.44** | **1,990,866,060.25** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,721,661,228.00** | **1,734,461,980.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,350,000.00** | **600,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,350,000.00 | 600,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,350,000.00 | 600,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,350,000.00 | 600,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,720,311,228.00** | **1,733,861,980.00** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,621,140,200.00 | 1,602,637,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 36,533,444.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 36,533,444.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 93,230,200.00 | 94,505,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 93,230,200.00 | 94,505,900.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 5,940,828.00 | 184,936.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 5,940,828.00 | 184,936.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,721,661,228.00** | **1,734,461,980.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,721,661,228.00** | **1,734,461,980.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,571,799,643.87** | **1,635,051,597.74** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,161,503,369.52 | 1,282,559,494.65 |
| 210101 | Үндсэн цалин | 1,109,680,769.52 | 814,017,457.37 |
| 210102 | Нэмэгдэл | 22,786,900.00 | 378,036,205.66 |
| 210104 | Урамшуулал | 29,035,700.00 | 90,505,831.62 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 266,764,442.32 | 176,085,721.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 266,764,442.32 | 176,085,721.09 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 92,580,200.00 | 92,794,310.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 14,097,990.00 | 18,311,990.88 |
| 210302 | Түлш, халаалт | 78,482,210.00 | 73,468,209.12 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 00.00 | 1,014,110.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 11,558,480.00 | 26,190,322.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,866,196.00 | 6,411,384.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,206,800.00 | 2,769,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,891,084.00 | 1,689,339.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 802,400.00 | 517,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 00.00 | 653,499.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 792,000.00 | 14,149,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 31,847,314.03 | 39,631,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 8,104,614.03 | 1,754,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 20,399,400.00 | 35,824,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,343,300.00 | 2,052,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 781,400.00 | 1,925,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 781,400.00 | 1,925,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 585,100.00 | 489,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 585,100.00 | 489,500.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,400,000.00 | 11,608,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 10,600,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,400,000.00 | 1,008,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,779,338.00 | 3,767,450.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 782,700.00 | 1,980,450.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,996,638.00 | 1,787,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **140,262,157.13** | **99,410,382.26** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 34,376,128.00 | 59,987,080.98 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 5,940,828.00 | 184,936.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 28,435,300.00 | 37,362,132.98 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 22,440,012.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 105,886,029.13 | 00.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 105,886,029.13 | 00.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 39,423,301.28 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 39,423,301.28 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,697,743,600.00 | 1,658,320,298.72 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,697,743,600.00 | 1,658,320,298.72 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,649,907,700.00 | 1,613,677,762.72 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,281,340,300.00 | 1,278,600,748.72 |
| 210101 | Үндсэн цалин | 888,387,500.00 | 926,618,199.63 |
| 210102 | Нэмэгдэл | 317,068,600.00 | 261,476,717.47 |
| 210104 | Урамшуулал | 75,884,200.00 | 90,505,831.62 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 172,981,000.00 | 169,703,538.59 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 121,727,400.00 | 118,449,938.59 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,813,400.00 | 12,813,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 10,250,700.00 | 10,250,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,562,700.00 | 2,562,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 25,626,800.00 | 25,626,800.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 92,580,200.00 | 92,794,310.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,682,500.00 | 18,311,990.88 |
| 210302 | Түлш, халаалт | 83,097,700.00 | 73,468,209.12 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 800,000.00 | 1,014,110.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 7,766,000.00 | 24,688,640.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 902,700.00 | 4,988,961.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,769,400.00 | 2,769,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,001,800.00 | 1,689,339.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 583,600.00 | 517,400.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 434,600.00 | 574,240.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,073,900.00 | 14,149,300.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 72,505,400.00 | 38,301,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 874,500.00 | 424,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 68,807,600.00 | 35,824,300.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,823,300.00 | 2,052,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,925,700.00 | 1,925,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,925,700.00 | 1,925,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 489,500.00 | 489,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 489,500.00 | 489,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,008,000.00 | 1,008,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,008,000.00 | 1,008,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 19311600.00 | 6166225.41 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,600,000.00 | 4,379,225.41 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 5,711,600.00 | 1,787,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 47835900.00 | 44642536.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 47,835,900.00 | 44,642,536.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 00.00 | 00.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 47,835,900.00 | 44,457,600.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,609,834,370,90 | 1,658,320,298.72 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,515,254,170,90 | 1,602,637,700.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,515,254,170,90 | 1,602,637,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 1,515,254,170,90 | 1,602,637,700.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,515,254,170,90 | 1,602,637,700.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 93,230,200 | 55,082,599.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 93,230,200 | 55,082,599.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 600,000.00 | 600,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 600,000.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 600,000.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 114.00 | 114.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 65.00 | 65.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 35.00 | 35.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 13.00 | 13.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 1,189.00 | 1,189.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1,189.00 | 1,189.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **36,533,444.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **14,093,432.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **14,093,432.00** |
| **2105** | **Нормативт зардал** | 1,330,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,330,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12763432.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,763,432.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 22440012.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 22,440,012.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 22,440,012.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 36533444.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 36,533,444.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 10,600,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 2,493,432.00 |

| | | |
|---|---|---|
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,440,012.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,000,000.00 |

## 3.Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын ЕБС-ийн Минжит булган цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд анхан шатны баримтын бүрдэл, дотоод хяналттай холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Эл Би Альфа аудит ХХК -ны аудитор Б.Бадамцэцэг 2022 оны 02 дүгээр сарын 10-наас 2021 оны 02 дугаар сарын 25–ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ны өдрийн 12 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Минжит Булган цогцолбор сургууль нь хүүхдийн сурах үйлийг дэмжиж сурлагын хоцрогдолгүй сургахад бүх талын оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлж, тэдний хөгжил төлөвшил, сурлагын амжилт чанарыг сайжруулах, багшийн мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг бүрдүүлэх зорилго дэвшүүлэн ажиллаж дараах зорилтуудыг хэрэгжүүлэн ажилласан байна. Үүнд.

- Эх хэлний чадварыг хөгжүүлэх
- Боловсролын үйлчилгээнд хүн бүр оролцогч байх чадамжийг дээшлүүлэх
- Суралцах чадвар, сургалтын чанарт ахиц гаргах
- Хүүхдэд ээлтэй эрүүл орчин бүрдүүлнэ

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн боловч шинэчлэл, тодотгол хийгдээгүй байна.

Ковид-19 цар тахалтай холбоотойгоо Боловсрол соёлын газар болон дотоод аудитын газар тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй, сумын санхүүгийн албанаас дотоод аудитын нэгжтэй боловч хяналт хэрэгжүүлсэн талаар ажлын тайлан ирүүлээгүй болно.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын ЕБС-ийн Минжит булган цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогоор сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл“Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 1801236,9 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 18.0 сая төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13.5 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган ЕБС-ийн Минжит булган цогцолбор сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 75,6 сая төгрөгөөр буюу 0.96 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна

Тайлант онд хөрөнгө бэлтгэх урьдчилгаа төлбөр 13.0 сая төгрөгөөр нэмэгдэж авлага өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 99.1 сая төгрөг болж 8.3 сая төгрөгөөр буюу аж ахуйн материал, нүүрс, хүнсний материал бэлтгэсэнтэй холбоотойгоор нэмэгдсэн байна.

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 134.5 сая төгрөгийн бараа материал бэлтгэж, 128.9 сая төгрөгийн материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 1984.2 сая төгрөг байсан бол оны эцэст 1890.2 сая төгрөг болж, 94.0 сая төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан элэгдэлтэй холбоотой байна . Тайлант онд акталж устгасан хөрөнгөгүй ба тайлант оны эцэст 1890.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Өр төлбөр оны эхэнд үлдэгдэлгүй байсан ба оны эцэст 11.4 сая төгрөг болж өссөн нь цалингаас суутгасан ХХОАТ, ҮЭ-ийн татвар 2,4 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн, ажилчдын амралтын цалин бодоход цалингийн программ алдаа зааж цалин зөрүүтэй олгосон байсныг суутгахдаа илүү суутгасантай холбоотой 9,9 сая төгрөг, нийт 11,4 сая төгрөгийг төсвөөс төлөхөөр өр үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны оны эхний үлдэгдэл 2077.9 сая төгрөг байсан оны эцэст 1990.8 сая төгрөг тайлант онд 87.1 сая төгрөгөөр буурсан нь өмнөх үр дүнд 0.3 сая төгрөгийн залруулга хийгдэж, тайлант үеийн үр дүн 86.7 сая төгрөгийн алдагдалтай байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган сумын ЕБС-ийн Минжит булган цогцолбор сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1697.7 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1697.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Боловсрол соёл шинжлэх ухааны яамнаас тус байгууллагын төсвийг 1697.7 сая төгрөгөөр батлан ирүүлжээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1697.7 сая төгрөгийн төсөв баталснаас 1602.6 сая төгрөгийг улсын төсвөөс, 94.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, өөрийн орлогоор 0.6 сая төгрөг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1602.6 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 94.5 сая төгрөг, өөрийн орлого 0.6 сая төгрөг, нийт 1697.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1658.3 сая төгрөгийг зарцуулж 39.42 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн тайлангаар Аймгийн ЗДТГ-аас 2,4 сая төгрөг , Боловсрол соёлын газраас 22.4 сая төгрөг, төсөл хөтөлбөрөөс 10.6 сая төгрөг, өөрийн орлогоор 1.0 сая нийт 36.4 сая төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай цалингаас суутгасан ХХОАТ, ҮЭ-ийн татвар 2,4 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн, ажилчдын амралтын цалин бодоход цалингийн программ алдаа зааж цалин зөрүүтэй олгосон байсныг суутгахдаа илүү суутгасантай холбоотой 9.9 сая төгрөг, нийт 11.4 сая төгрөгийг төсвөөс төлөхөөр өр үүсгэсэн зөрчил байна.

**3.8 АУДИТЫН ГОЛ АСУУДАЛ**

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 138 хугацаандаа оруулснаас 5 гүйлгээ хугацаа хоцроосон, 4 мэдээлэл хугацаа болоогүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий 6 гүйлгээг мэдээлээгүй тухай бүр шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

**ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж, 1 албан шаардлага, 2 акт тавигдсан бөгөөд бүрэн 96 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

НДШ-ийн тайлангийн тооцоолoлтой холбоотой 1.5 сая төгрөгийг санхүүгийн программын бичилтээр алдаатай тайлагнасныг залруулаагүй бөгөөд цаашид тооцоолол төлөлттэй холбоотой ажлыг хянамгай хийж тайлагнахыг зөвлөж дахин зөрүү гаргахгүй ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 144.08 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, Жайка төслөөс, ОБГ-аас үнэ төлбөргүй олгосон 1.3 сая төгрөгийн ариутгалын бодис, автомаск, үнэгүй хүнсний ногоо 0.1 сая төгрөгийг орлого аваагүй байсныг орлого авхуулж, буцсан гүйлгээ болох 0.4

сая төгрөгийг орлогоор тайлагнасан байсныг нийт 1.8 сая төгрөгийн залруулга хийлгэж, цалин илүү олгосонтой холбоотой 0.38 сая төгрөгийг төлбөрийн акт тогтоож, 141.9 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

**4.1 Цалинтай холбоотой асуудал:**

***Илрүүлэлт:*** Орон тоо батлагдаагүй ажил хавсарсан цалингийн нэмэгдэл 386.0 мянган төгрөгийг захирал Ц.Сонгуульд олгосон зөрчил илэрлээ.

***Өгсөн зөвлөмж:*** Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “ төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, нягтлан бодох бүртгэлийн 13-р зүйлийн 13,6-д “анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянаж ажил, гүйлгээг гарахаас өмнө хянан баталгаажуулах”, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.2-д "Шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, Төсвийн тухай хуулийн 16-р зүйлийн 16.5.3 “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.***

**4.2 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***4.2.1. Дотоод хяналттай холбоотой асуудал***

***Илрүүлэлт:*** Дотоод хяналтын баг хийх ажлын төлөвлөгөөгүй хяналт хэрэгжүүлээгүйгээс хоол, материалын зарцуулалтад тавих хяналт сул, хүнс их хэмжээний үлдэгдэлтэй, аж ахуйн материалын зарцуулалтыг хянаагүй зөрчил илэрлээ.

***Өгсөн зөвлөмж:*** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д "анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна" , Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын 1.3-д "аж ахуйн нэгж, байгууллага нь энэхүү нийтлэг журамд нийцүүлэн, өөрийн үйл ажиллагааны онцлогт тохирсон "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-тай байна", 1.5-д "... Журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам" тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллах

***4.2.2 Ерөнхий чиглэл***

***Илрүүлэлт:*** Засгийн газрын 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсөвт зардлын 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаагүй, төсөвт төвлөрүүлээгүй 130.3 сая төгрөгийн зөрчил илэрлээ.
***Өгсөн зөвлөмж***: Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны 43 дугаар тогтоолын 1.1-д "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад

бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалтыг хэрэгжүүлж ажиллах

### *4.2.3. Авлага өглөгийн талаар:*

***Илрүүлэлт:*** Цалингаас суутгасан ХХОАТ, ҮЭ-ийн татвар 2,4 сая төгрөгийг дутуу шилжүүлсэн, ажилчдын амралтын цалин бодоход цалингийн программ алдаа зааж цалин зөрүүтэй олгосон байсныг суутгахдаа илүү суутгасантай холбоотой 9.9 сая төгрөг, нийт 11.4 сая төгрөгийг төсвөөс төлөхөөр өр үүсгэсэн зөрчил илэрлээ.

***Өгсөн зөвлөмж:*** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1-д Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална", 5.1.3- д "жинхэнэ хэрэгжилтийн", 13.1-д "анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв, гаргах үндэслэл болно" 20-р зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;, 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч худалдан авагчтай тооцоо хийж үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, хэрэгжилтийг хангах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая. төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Булган сумын ЕБС-ийн Минжит булган сургууль | 7 | 144.08 | 3 | 1.8 | 1 | 0.38 | 0 | 0 | 3 | 141.9 |

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН**

**ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Х.БОЛДБААТАР**

**АУДИТЫН МЕНЕЖЕР: А.ЦЭЦЭГСҮРЭН**

**ТАЙЛАНГ БИЧСЭН**

**ЭЛ БИ ЭКСПЭЙНШИН АЛЬФА АУДИТ ХХК-НЫ**

**АУДИТОР: Б.БАДАМЦЭЦЭГ**